

БАТЛАВ:  
**НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН**  
**ДАРГА**

Б.МӨНХБАТ

**ХӨНГӨН ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН МАЛ, АМЬТНЫ ГАРАЛТАЙ БИОЛОГИЙН  
ХАЯГДАЛ УСТГАЖ, АЮУЛГҮЙ БОЛГОХ ЦОГЦОЛБОР БАРИЛГЫН ЗУРАГ ТӨСӨВ  
БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАР**

2023 оны 04-р сарын 13-ны өдөр      Дугаар №2023/39      Улаанбаатар хот

1.	Зураг төсөл боловсруулах үндэслэл	Нийслэлийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн А/554 дүгээр захирамж. Хот байгуулалт хөгжлийн газрын 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн МЗХ2023/09-004 дугаартай архитектур төлөвлөлтийн даалгавар.
2.	Барилга байгууламжийн байршил	Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороо,
3.	Зориулалт хүчин чадал	Хөнгөн хүнсний үйлдвэрлэлийн мал, амьтны гаралтай биологийн хаягдал устгаж, аюулгүй болгох цогцолбор барилга
4.	Төслийн гүйцэтгэх хугацаа	-Захиалагч, гүйцэтгэг талуудын хооронд байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгоно.
5	Инженерийн шугам сүлжээ, түүнийг хангах эх үүсвэр	<ul style="list-style-type: none"> <li>- Загвар зураг төслийг боловсруулж баталгаажуулсны дараа ачаалал тооцож хангагч байгууллагуудаас техникийн нөхцөлүүдийг гаргуулах, шаардлагатай тохиолдолд өөрийн эх үүсвэрээр хангах зураг төсөв боловсруулж холбогдох байгууллагуудаар зөвшилцнө.</li> <li>- Төслийн талбайд шугам сүлжээ илэрвэл зөөх шилжүүлэх техникийн нөхцөл гаргуулах бөгөөд тухайн шугам сүлжээний зөөх шилжүүлэх ажлын зураг болон зардал, авто зам, зам талбайн нөхөн сэргээлтийн зардлыг төсөвт тусгаж мэргэжлийн байгууллагатай зөвшилцнө баталгаажуулах</li> </ul>
5.	Төслийн иж бүрдэл	<p><u>Баримт бичгийн иж бүрдэл:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Байр зүйн дэвсгэр зураг боловсруулах</li> <li>- Инженер геологийн дүгнэлт</li> <li>- Инженерийн шугам сүлжээний тодруулга</li> <li>- Одоо байгаа барилгын хэмжилтийн зураг</li> <li>- Онцгой байдлын дүгнэлт</li> <li>- Мэргэжлийн хяналтын газрын дүгнэлт</li> <li>- Магадлалын нэтгэсэн дүгнэлт /Хавсралт дүгнэлтийн хамт/</li> </ul> <p><u>Ажлын зургийн иж бүрдэл:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Нүүр хуудас /батлагдах/</li> <li>- ЕТ- Ерөнхий төлөвлөгөө, өндөржилт</li> <li>- ГТ- Гадна тохижилтын иж бүрэн зураг,</li> <li>- БА- Барилга архитектур</li> <li>- ТХ-Технологийн зураглал</li> <li>- ББ- Барилга бүтээц / Бүтээцийн тооцооны хамт/</li> <li>- ХС- Халаалт, салхивч</li> <li>- ЦБУ- Усан хангамж, ариутгах татуурга</li> <li>- ЦА- Цахилгаан хангамж</li> <li>- ХД- Холбоо дохиолол</li> <li>- ГД- Гадна дулаан</li> </ul>

		<ul style="list-style-type: none"> <li>- УАТГ- Гадна усан хангамж ариутгах татуурга</li> <li>- ГЦ- Гадна цахилгаан</li> <li>- ГХ- Гадна холбоо</li> <li>- Барилгын төсөв /Тооцооны ESTIMATOR-PRO программ/</li> </ul> <p><u>Зураг төсөлд тавигдах шаардлага:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Тохиижилтын элементүүдийг норм дүрмийн дагуу төлөвлөх ба ерөнхий харагдах байдлыг 3D буюу 3 хэмжээст зураглалаар гүйцэтгэх;</li> <li>- Зураг төслийг хот байгуулалтын мэдээллийн санд хүлээж авахад тавигдах шаардлага.</li> </ul> <p>a. Хот байгуулалтын мэдээллийн сангийн стандартыг мөрдөх.</p> <ul style="list-style-type: none"> <li>- б.Хийгдэж буй төслийн дэвсгэр зургийн WGS-84, UTM буюу солбицлын нэгдсэн тогтолцоонд хийж гүйцэтгэх.</li> </ul>
6.	Зураг төсөл боловсруулах үе шат	<ul style="list-style-type: none"> <li>- Ажлын зураг төсөв хоёр үе шаттай:</li> <li>- Эх загвар зураг боловсруулж, батлуулах:</li> <li>- Ажлын зураг төсөв боловсруулж, зөвшилцөж, батлуулах</li> </ul>
7.	Зураг төслийн байгууллага	<ul style="list-style-type: none"> <li>- Барилга хот байгуулалтын сайдын тушаалаар батлагдсан "Хот байгуулалтын баримт бичиг, барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт засвар, үйлчилгээ, материалын үйлдвэрлэл, угсралт засвар, үйлчилгээ, материалын үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл олгох журам"-ын Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөлтэй эрх бүхий хуулийн этгээд:</li> </ul>
8.	Захиалагч байгууллага	<ul style="list-style-type: none"> <li>- Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар</li> <li>- Нийслэлийн Мал эмнэлгийн газар</li> </ul>
9.	Онцгой нөхцөл	<ul style="list-style-type: none"> <li>- Тус ажил нь тухайлсан ажлын зураг, төсөвгүй бөгөөд зургийг тухайн байршилд тохируулан ерөнхий төлөвлөгөөг боловсруулж эх загвар зургийг ашиглагч, захиалагчтай зөвшилцөж батлуулна.</li> <li>- Батлагдсан загвар зургийг үндэслэн шугам сүлжээний ачаалал тооцож хангагч байгууллагуудаас техникийн нөхцөлүүдийг гаргуулан ажлын зураг, төсвийг иж бүрэн боловсруулна,</li> <li>- Олгогдсон техникийн нөхцөлийн хүрээнд гадна инженерийн шугам, сүлжээний зураг, төсөв боловсруулан холбогдох байгууллагуудтай зөвшилцэн, батлуулна.</li> <li>- Гадна инженерийн шугам сүлжээний ажилд зам талбай буулгах болон нөхөн сэргээх зардлыг тооцох</li> <li>- Барилгын сууринд авто зам, нийтийн эзэмшлийн зам талбай давхцаж байгаа бол буулгах ажлын тоо хэмжээ, зардлыг тооцох</li> <li>- Харуул, хяналтын байр</li> <li>- Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж гэх мэт цэвэрлэх, халдвартгүйтгэлийн байр, талбай</li> <li>- Хүүр сэг зэм буулгах талбай /битүү/</li> <li>- Хүүр сэг зэм бутлах байр</li> <li>- Шатаах зуухны байр</li> <li>- Беккарын нүх /15 куб/м/ ханатай,</li> <li>- Үнс хадгалах байр /битүү/</li> <li>- Автомашины гараж-3 /ачааны машин/</li> </ul>

- Санал болгох үнийн дунд инженер геологи, дэвсгэр зураг, загвар зураг төсөл, гадна инженерийн шугам сүлжээний зураг төсөв, инженерийн шугам сүлжээний тодруулга /газар доорх шугам сүлжээг чагнуулах/ тухайлсан барилгын ажлын зураг төсвийн үнэ, ба барилга, дотор шугам сүлжээ, гадна шугам сүлжээ, байгууламжийн барилга угсралтын ажлын хөрөнгө бүгд багтсан байна. Мөн тухайн ажилтай холбоотой гарч болох бүхий л зардлыг нарийвчлан багтаасан байх.
- Тендерт үнийн санал ирүүлэхдээ газар дээр нь судалж төлөвлөж буй байршлын хөрс, өндөржилт, иж бүрэн зураг төсөв, барилга, гадна тохижилт /хашаа, зогсоол, гэрэлтүүлэг, явган зам талбай, ногоон байгууламж/, гадна дотор инженерийн шугам сүлжээ, гадна шугам сүлжээний барилга байгууламжийг тооцох.
- Ажлын зураг төсвийг боловсруулж магадлалаар баталгаажуулсны дараа угсралтын ажлыг эхэлнэ.

Барилга байгууламж:

- Эрчим хүчний хэмнэлттэй, ашиглалтын зардал бага байх
- Барилгын онцлогийг архитектур орон зайн өвөрмөц шийдэлтэй байхаар тусгах
- Олон нийт иргэний барилгын норм дүрмийг хангах
- Барилгын өрөө тасалгаанд байгалийн болон орон зайн гэрэлтүүлэг сайтай байхаар ерөнхий төлөвлөгөөг боловсруулах
- Төлөвлөлт болон барилгын өрөө тасалгааг ашиглагчтай зөвшилцэж тодорхойлно.
- Барилгын аврах гарцыг нормын дагуу төлөвлөх ба саадгүй түргэн аврагдах гарцыг төлөвлөх

Гадна талбай:

- Борооны ус зайлцуулах байгууламжийг өндөржилттэй уялдуулан норм дүрмийн дагуу төлөвлөх
- Барилгын орц гарцыг гадна авто замтай болон явган замын хөдөлгөөнтэй уялдуулан төлөвлөх
- Ногоон байгууламж ба амрах талбай төлөвлөн, зам талбайд гэрэлтүүлэг хийж гадна талбайн тохижилтыг норм дүрмийн дагуу төлөвлөх

Инженерийн шугам сүлжээ:

- Эдэлбэр газарт газрын зураглалын тодруулалт хийлгэх, газар доорх болон дээрх шугам сүлжээг тодруулсны үндсэн дээр холболтын зураг төслийг боловсруулах
- Инженерийн шугам сүлжээний тодруулгаар газар доор шугам сүлжээ илэрвэл зөөх шилжүүлэх ажлын зураг болон зардлыг тооцох
- Инженерийн шугам, сүлжээний техникийн нөхцөлийн дагуу нийтийн эзэмшлийн зам талбайг дайрч байгаа тохиолдолд буулгалт болон нөхөн сэргээлтийн ажлыг төсөвт тусгах
- Агааржуулалтын системийг олон нийтийн барилгын шаардлага орчинд нийцсэн дэвшилтэт технологийн шийдэл бүхий тоног төхөөрөмжтэй төлөвлөх

		<ul style="list-style-type: none"> <li>- Ослын гэрэлтүүлгийг орц гарц, коридорт төлөвлөх</li> <li>- Мэдээлэл харилцаа, холбоо дохиоллын инженерийн шугам сүлжээний хэрэгцээ шаардлагыг хангахуйц төлөвлөх.</li> <li>- Гадна хяналтын камер төлөвлөх</li> <li>- Газар хөдлөлийн тэсвэршилийг тухайн байршилд хийгдсэн инженер геологийн дүгнэлтийг үндэслэнэ.</li> </ul>
10.	Зураг тесөл боловсруулахад ашиглах материал	<p><u>Хууль тогтоомжууд:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Газрын тухай болон Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль</li> <li>- Барилгын тухай хууль</li> <li>- Эрүүл мэндийн тухай хууль</li> <li>- Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль</li> </ul> <p><u>Норм, нормативууд:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Барилгын инженер геологийн ажил /БНБД 11-03-01/</li> <li>- Барилгын геодезийн ажил /БНБД 11-08-06/</li> <li>- Барилга захиалагчийн дүрэм</li> <li>- Барилгын бүтээц ба буурийн найдваршил. Ерөнхий шаардлага /БНБД 20-01-11/</li> <li>- Ачаалал ба үйлчлэл /БНБД 20-04-17/</li> <li>- Барилга, байгууламжийн галын аюулгүй байдал /БНБД 21-01-02</li> <li>- Барилга, байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм /БНБД 21-02-02/</li> <li>- Газар хөдлөлийн бус нутагт барилга төлөвлөх барилгын норм ба дүрэм /БНБД 22-01-01*/</li> <li>- Барилгад хэрэглэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлт /БНБД 23-01-09/</li> <li>- Байгалийн ба зохиомол гэрэлтүүлэг /БНБД 23-02-08/</li> <li>- Барилгын дулаан хамгаалалт /БНБД 23-02-09/</li> <li>- Дуу чимээ тусгаарлалт /БНБД 23-05-10/</li> <li>- Олон нийт иргэний барилга /БНБД 31.03.03/</li> <li>- Ариутгах татуурга. Гадна сүлжээ ба байгууламж/БНБД 40-01-14/</li> <li>- Усан хангамж. Гадна сүлжээ ба байгууламж /БНБД 40-02-06/</li> <li>- Барилга доторх усан хангамж, ариутгах татуурга /БНБД 40-05-98/05*/</li> <li>- Дотор сантехникийн ажил /БНБД 3.05.01-88/</li> <li>- Усан хангамж, бохир ус, гадна шугам, түүний барилга байгууламж /БНБД 3.05.04-90/</li> <li>- Халаалт, агаар сэлгэлт ба кондиционер /БНБД 41-01-11/</li> <li>- Дулааны сүлжээ /БНБД 41-02-13/</li> <li>- Дулааны шугам сүлжээ /БНБД 3.05.03-95/</li> <li>- Цахилгаан техникийн ажил /БНБД 3.05.06-90/</li> <li>- Автоматжуулалтын систем /БНБД 3.05.07-90/</li> <li>- Бетон ба төмөр бетон бүтээц. Ерөнхий журам /БНБД 52-01-10/</li> <li>- Барилгын бүтээц, ажлын төрлеөр төсвийн суурь норм, түүний хавсралтуудыг боловсруулах хэрэглэх дүрэм /БНБД 81-10-02/</li> <li>- Барилгын үнэ бүрдлийн үндсэн дүрэм /БНБД 81-94-12/</li> <li>- Барилгын төсөв зохион дүрэм /БНБД 81-95-12/</li> <li>- Цахилгаан техникийн ажил /БНБД 3.05.06-90/;</li> <li>- Хот суурины гудамж, зам төлөвлөлт /БНБД 32-01-04/</li> </ul>

		<ul style="list-style-type: none"> <li>- Барилгын орчны тохижилтын ажил /БНБД 3.01-06-90/</li> <li>- Орчны аюулгүй байдал: Барилга, замын ажил гүйцэтгэхэд иргэдийн аюулгүй байдлыг хангах ерөнхий шаардлага UCS0001-01:2019</li> <li>- Иж бүрэн гудамж: Хашаа, хайс, хашлаганд тавигдах ерөнхий шаардлага хэрэгцээ UCS0001-02:2019</li> <li>- Гадна орчны тохижилт: Хүүхдийн тоглоомын талбайн эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэхэд тавигдах ерөнхий шаардлага UCS0002-02:2019</li> <li>- Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцэх, магадлал хийх дүрэм</li> <li>- Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм /БНБД 30-01-04/;</li> <li>- Барилгын орчны тохижилтын ажлын норм ба дүрэм /БНБД 3.01-06-90/;</li> <li>- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хетөч зам, налуу шатыг шийдэх /MNS 6056:2003, 6055:2009/;</li> <li>- Барилгын төсөв зохиох дүрэм БНБД 81-95-12</li> <li>- Бусад холбогдох норм, дүрэм;</li> </ul> <p><u>Төсөл, хетөлбөрүүд:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Нийслэл Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлага;</li> </ul>
12.	Галын аюулгүй байдлын нөхцөл	Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүй норм /БНБД 21.01.02/, /БНБД 21.02.02/
13.	Эдийн засгийн тооцоо, төсөв	Төсвийг ESTIMATOR-PRO программ болон бусад зохих эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн бусад программаар тооцох.

ХЯНАСАН:

НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ЗТХ-ИЙН ДАРГА

..... /Б.ЛХАГВАЖАВ/

БОЛОВСРУУЛСАН:

НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ЗТХ-ИЙН ХЯНАЛТЫН ИНЖЕНЕР

..... /Э.БАТЦЭНГЭЛ/